



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/03

Эрдэнэт

**Орхон аймгийн газар зохион байгуулалтын  
2022-2037 оны ерөнхий төлөвлөгөөг  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн газар зохион байгуулалтын 2022-2037 оны ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2.Орхон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгон хэрэгжүүлж, дараах арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай;

2.1.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэл, хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагдсан ажлуудыг аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөө болон улс орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ерөнхий төлөвлөгөөний бүрдэл материалуудыг багтаасан ном болгон хэвлүүлж сум, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

2.2.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх газруудыг байршил, хилийн зааг хэмжээг газар дээр нь нарийвчлан тогтоож, олон нийтэд мэдээлэх, хамгаалалтад авах;

2.3.Аймгийн газар зохион байгуулалт, газрын харилцааны холбогдолтой бодлогын баримт бичгүүдийг энэхүү ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсронгуй болгох;

3.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж мөрдлөг болгохын тулд өөрийн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан баталж мөрдөх, эдгээр баримт бичигтэй сумын төвийн хөгжлийн төлөвлөгөөгөө уялдуулах арга хэмжээ авахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

ДАРГА

Д.МӨНХБАТ

C:\My documents\tootool

079110554

**ОРХОН АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ**

**НЭГ. Бичиглэлийн материал:**

I боть. Орхон аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө (106 хуудас)

- Орхон аймгийн байгаль, цаг уур, нийгэм, эдийн засгийн нөхцөл

II боть. Орхон аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө (134 хуудас)

- Нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв
- ХАА-н газрын менежментийн бүс, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт
- Хот суурин газрын менежментийн бүс, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт
- Зам, шугам сүлжээний газрын менежментийн бүс, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт
- Ойн сан бүхий газрын менежментийн бүс, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт
- Усны сан бүхий газрын менежментийн бүс, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт
- Аялал жуулчлалын өнөөгийн байдал, хэтийн төлөв
- Орхон аймгийн ТХГН-ийн сүлжээ, өнөөгийн байдал, хэтийн төлөв
- Орхон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд олон нийтийн оролцоо, цахим болон ярилцлагын санал асуулгын үр дүн

**ХОЁР. Зураглалын материал:**

Орхон аймгийн байгаль нутаг дэвсгэрийн нөхцөл нөөц болон төлөвлөлтийн зураг бүхий катологи (49 хуудас)

- Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь
- Орхон аймгийн геоморфологийн нөхцөл
- Орхон аймгийн газрын гадаргын хэвгий
- Орхон аймгийн газрын гадаргын өндөржилт
- Газрын гадаргын зүг зовхис
- Орхон аймгийн геологийн тогтоц
- Орхон аймгийн инженер-геологийн нөхцөл
- Орхон аймгийн гидрогеологийн нөхцөл
- Орхон аймгийн нийт гүний усны урсцын түвшин
- Орхон аймгийн цэвдгийн тархалт
- Орхон аймгийн газар чичирхийллийн мужлал
- Орхон аймгийн агаарын температур
- Орхон аймгийн хур тунадасны жилийн нийлбэр
- Орхон аймгийн хөрсний хэв шинж
- Орхон аймгийн ургамалжилтын хэв шинж
- Орхон аймгийн ургамлын нормчлогдсон индекс

- Орхон аймгийн нутагт тархсан амьтны тархалт
- Орхон аймгийн түүх, өв соёлын дурсгалт газар
- Орхон аймгийн аймгийн ашигт малтмалын зураг
- Орхон аймгийн хөдөө аж ахуйн газар
- Орхон аймагт зонхилох бэлчээрийн төрөл
- Орхон аймгийн бэлчээрийн төрх байдал
- Хадлан бэлтгэх тохиромжтой талбайн төлөвлөлт
- Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ
- Тариалангийн газар ашиглалтын өнөөгийн байдлын зураг
- Тариалангийн талбайн хамгаалалтын бүс
- Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас газрын төлөвлөлт
- Баян-Өндөр сумын Хот тосгон, бусад суурины газрын зураг
- Жаргалант сумын Хот тосгон, бусад суурины газрын зураг
- Баян-Өндөр сумын газар ашиглалт, 2021 он
- Жаргалант сумын газар ашиглалт, 2021 он
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын үерийн эрсдэлийн үнэлгээ
- Орхон аймгийн Жаргалант сумын үерийн эрсдэлийн үнэлгээ
- Сумдын төвийн суурьшсан хэсгийн үерт өртөж болзошгүй байдал
- Баян-Өндөр сумын төвийн газар ашиглалтын одоогийн бүсчлэл
- Жаргалант сумын төвийн газар ашиглалтын одоогийн бүсчлэл
- Баян-Өндөр сумын газар ашиглалтын бүсчлэлийн төлөвлөлт
- Жаргалант сумын газар ашиглалтын бүсчлэлийн төлөвлөлт
- Жаргалант сумын авто замын сүлжээний зураг
- Баян-Өндөр сумын авто замын сүлжээний зураг
- Авто замын сүлжээний нягтрал
- Авто зам болон хөрсөн замд өртөж буй амьтны тархалт
- Төмөр замын сүлжээний төлөвлөлт
- Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн төлөвлөлт
- Ойн сан бүхий газрын газар ашиглалтын байдал
- Орхон аймгийн ойн таксацын үзүүлэлт
- Орхон аймгийн ойн төрөл зүйл
- Ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөл
- Нөхөрлөлд эзэмшүүлэх боломжтой ойн сан бүхий газрын байршил
- Ойжуулах боломжтой талбайн зураг
- Ойн сан бүхий газрын менежментийн нэгдсэн төлөвлөлт
- Гадаргын болон гүний усны сүлжээ
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төлөвлөлт
- Усны сан бүхий газрын менежментийн төлөвлөлт
- Аялал жуулчлалын газрын төлөвлөлт, аяллын маршрут
- ОНТХГ-т авах шаардлагатай газар нутаг